



МОНГОЛ АЛТ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

20 ~~24~~ оны ~~04~~ сарын ~~29~~ ны өдөр

№ ~~01~~

Улаанбаатар хот

Компанийн 2023 оны санхүүгийн тайлан,
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн
гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.11, 62 дугаар зүйлийн 62.1.9, “Монгол алт” ХК-ийн дүрмийн 8.4.9 дэх заалт, Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 02 тоот тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол алт” ХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн тайланг баталсугай.

2. Тус компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөг баталж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг шинээр байгуулагдах Төлөөлөн Удирдах Зөвлөлд, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (М.Цолмон)-д тус тус үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.АМАРСАНАА



МОНГОЛ АЛТ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2024 оны 04 сарын 29-ны өдөр

№ 02

Дархан хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны зардлын төсөв, ТУЗ-ийн дарга, гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, “Монгол алт” ХК-ийн дүрмийн 8.7 дахь хэсэг, Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 03 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол алт” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хэвийн үйл ажиллагаа хангах 2024 оны зардлын төсвийг 5,220,000 төгрөгөөр тогтоосугай.
2. “Монгол алт” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга, гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах зардлыг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал (М.Цолмон)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.АМАРСАНАА



"Монгол алт" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 02 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮДИЙН ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭ**

№	ТУЗ-ийн гишүүний нэр	1 сарын цалин /төг/	1 жилийн цалин /төг/
1	Ердийн гишүүн ТУЗ-н дарга	50000	600000
2	Ердийн гишүүн	45000	540000
3	Ердийн гишүүн	45000	540000
4	Ердийн гишүүн	45000	540000
5	Ердийн гишүүн	45000	540000
6	Ердийн гишүүн	45000	540000
7	Хараат бус гишүүн	45000	540000
8	Хараат бус гишүүн	45000	540000
9	Хараат бус гишүүн	45000	540000
10	Нарийн бичгийн дарга	25000	300000
	Нийт	435000	5220000

oOo



МОНГОЛ АЛТ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2024 оны 04 сарын 29-ны өдөр

№ 03

Дархан хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.4, “Монгол алт” ХК-ийн дүрмийн 8.4.7, Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01 тоот тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ НЬ:

1. “Монгол алт” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай.

1.1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр:

- 1.1.1. Л.Амарсанаа
- 1.1.2. М.Цолмон
- 1.1.3. М.Оюун
- 1.1.4. Ж.Мөнхтөр
- 1.1.5. А.Молор-Эрдэнэ
- 1.1.6. Б.Цэлмэг

1.2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр:

- 1.2.1. О.Лувсаншарав
- 1.2.2. С.Дорждэрэм
- 1.2.3. Л.Базарсад

2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлыг 2024 оны 06 дугаар сард багтаан хуралдуулж Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга, түүний дэргэдэх хороодыг байгуулах ажлыг шинээр сонгогдсон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн оролцоотойгоор зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (М.Цолмон)-д үүрэг болгосугай.

3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн анхны хурлаа зохион байгуулж, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга сонгох, компанийн засаглалын журам, баримт бичгүүдийг хэлэлцэх, цаашид хууль тогтоомж, компанийн дүрэм, компанийн засаглалын журмуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгосугай.

4. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шинээр сонгогдсон ердийн болон хараат бус гишүүдийн талаарх мэдээллийг Хувьцаа эзэмшигчид, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид мэдэгдэхийг Гүйцэтгэх захирал (М.Цолмон)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга (С.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

6. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан “Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох тухай” “Монгол алт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 04 тоот тогтоол, 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 02 дугаар тогтоолын 2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.АМАРСАНАА